



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

10
АНГИ

ТҮҮХ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

1. “Монголын өвөг түүх”-ийн үед холбогдох үечлэл аль вэ?
А. Монголын эртний улсуудын үе
В. Монголын эзэнт гүрний үе
С. Чингисийн эрин үе
D. Нүүдлийн иргэншлийн үе
2. Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүсийн олзворлох, түүвэрлэх аж ахуй аль үед хамаарах вэ?
А. Мезолит ба Неолит
В. Палеолит ба Неолит
С. Неолит ба Энеолит
D. Палеолит ба Мезолит
3. Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүсийн үйлдвэрлэх аж ахуйн үечлэл аль вэ?
А. 800.000-12.000 жилийн өмнө
В. 12.000-8.000 жилийн өмнө
С. 8.000-НТӨ III мянган
D. НТӨ III мянган – НТӨ IV зуун
4. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Нарийн голын хөндийн бууцнаас Монгол нутагт эртний хүн анх амьдарч байсны гэрч болох ямар зэвсэг олдсон бэ?
А. Хүрэл зэвсэг
В. Чулуун зэвсэг
С. Төмөр зэвсэг
D. Модон зэвсэг
5. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу?
Эртний хүмүүс хайргаар зэвсэг хийхдээ бэлдцээс үлдэц, цуулдас гаргах аргыг олсон нь бүтээх үндсэн арга болж хөгжив.
А. хүрэл зэвсэг
В. төмөр зэвсэг
С. модон зэвсэг
D. чулуун зэвсэг
6. Дээд палеолитын үед зурсан, хадны зургийн дурсгалт газар аль вэ?
А. Ховд аймаг, Манхан сумын Хойд цэнхэрийн агуй
В. Дорнод аймаг, Халх гол сумын Тамсагбулаг суурин
С. Баянхонгор аймаг, Баян-Овоо сумын Нарийн голын бууц суурин
D. Өвөрхангай аймаг, Хархорин сумын Мойлтын ам
7. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.
“Сяньби угсааны Муюн улсыг үндэслэгч 285 онд азарганы ноцолдооноос болж ах Түгүхүнтэйгээ муудалцан, хөөж явуулсандаа хожим гэмшин, ахаа санан “Ахын дуу”-г зохион дуулсан ажээ. Ах нь албат иргэдээ дагуулан алс баруун зүг нүүж, Хөх нуурт очиж нутаглан, улсыг байгуулсан юм.
А. Модун, Хүннү
В. Таньшихуай, Сяньби
С. Буман, Түрэг
D. Муюн, Тогон
8. Хүннү гүрнийг НТӨ 209 онд байгуулсан шаньюй аль вэ?
А. Түмэн
В. Модунь
С. Буман
D. Гүнчэн
9. НТӨ 198 онд Хүннү улс ямар улстай энх ургийн гэрээ байгуулсан бэ?
А. Цинь
В. Хань
С. Мин
D. Дунху
10. Жамуха, Тэмүжин хоёрын хооронд болсон 1190 оны тулаан хаана болсон бэ?
А. Хар зүрхний хөх нуурт
В. Наху Гүнд
С. Онон мөрний хөвөөнд
D. Далан Балжудад

11. Чингис хааны Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг аль вэ?
 А. Монгол угсаатныг нэгэн төрийн жолоонд оруулсан
 В. Монголчууд овог, аймгаараа амьдрах болсон
 С. Эрийн гурван наадмыг санаачлан, монголчуудыг соёлын хувьд нэгтгэсэн
 Д. Өрнө дорныг холбосон эдийн засаг, соёлын харилцааг хөгжүүлсэн
12. Их Монгол улсын ямар хааны үед Алтан улсыг бүрэн мөхөөсөн бэ?
 А. Чингис хаан В. Өгэдэй хаан С. Хубилай хаан Д. Мөнх хаан
13. Хубилай хаан улсын нэрийг “Их Юань” гэж хэзээ өөрчилсөн бэ?
 А. 1260 онд В. 1264 онд С. 1271 онд Д. 1294 онд
14. Эсэн тайшийн төр барьсан үе аль вэ?
 А. 1389-1392 он В. 1433-1452 он С. 1453-1454 он Д. 1454-1465 он

15. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.



- А. “Түмү”-гийн хэрэг, Эрдэнэ зуу хийдийг байгуулав.
 В. Содномжамцад “Далай лам” цол соёрхов. 108 боть Ганжуур-ыг орчуулж хэвлэв.
 С. Монголын улс төр төв эх нутагтаа шилжив. Дөчин, Дөрвөн хоёр “Их цааз”-ыг батлав.
 Д. Батмөнх Даян хаан Монголыг захирав. Занабазарыг Анхдугаар Богдоор өргөмжлөв.
16. 1223 онд Монголчууд Кипчакийн холбоотон Оросын вангуудын нэгдсэн хүчийг Калка голын хөвөөнд бут цохижээ. Уг үйл явдал хэддүгээр зуунд, буюу одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ?
 А. XIII зуун, буюу 800 жилийн өмнө В. XIII зуун, буюу 3246 жилийн өмнө
 С. XII зуун, буюу 800 жилийн өмнө Д. XII зуун, буюу 3246 жилийн өмнө
17. Монгол нутаг дахь эртний хүмүүс анх оюун санааны ертөнц, итгэл үнэмшлээ хадны зургаар илэрхийлэх болсон нь чулуун зэвсгийн аль үед холбогдох вэ?
 А. Доод палеолит В. Дунд палеолит С. Дээд палеолит Д. Мезолит
18. Монголчуудын гол аж ахуй нь нүүдлийн мал аж ахуй бөгөөд хэдий үеэс бие даан хөгжих болсон бэ?
 А. Неолитын үед В. Хүрэл, түрүү төмрийн үед
 С. Хүннү гүрний үед Д. Хүннүгийн дараах улсуудын үед
19. Талын малчин аймгуудын үндсэн аж ахуй юу вэ?
 А. Газар тариалан В. Нүүдлийн мал аж ахуй С. Гар урлал Д. Ан гөрөө
20. XII зууны үеийн Монгол аймаг улсууд төв, баруун, зүүн гэсэн гурван гарын тогтолцоог аль улсаас уламжлан авсан бэ?
 А. Түрэг улс В. Алтан улс С. Хүннү улс Д. Уйгур улс
21. XII зууны үеийн Монгол аймаг улсууд нь аж ахуйгаа ямар зохион байгуулалтаар эрхлэн хөтөлж байсан бэ?
 А. Эцгийн эрхт овгийн хэлбэрээр В. Төв, баруун, зүүн гарын хэлбэрээр
 С. Хүрээ хэлбэрээр Д. Хот айлын хэлбэрээр

22. Бурхны шашин Монголчуудын оюуны санааны цөм болсныг аль нь илэрхийлж байна вэ?
- А. Монголын эрх баригчид улсынхаа нэгдмэл байдлыг сэргээхийн тулд шашин дэлгэрүүлсэн.
 - В. Монголын эрх баригчид Төвөдөд нөлөөгөө тогтоохын тулд шашныг ашигласан.
 - С. Монголд бурхны шашны урсгалууд өөрсдийн нөлөөг дэлгэрүүлэхийн тулд өрсөлдсөн.
 - Д. Монгол нутагт Энэтхэг, Төвөдийн шашны ном судрыг монголчлох ажил эрчимтэй хөгжсөн.
23. Юань улсын үед хүн амаа 4 зэрэглэлд хувааж байв. Хамгийн доод зэрэглэлд орж, хамгийн бага эрх эдэлдэг байсан нь аль вэ?
- А. Монгол хүн
 - В. Өмнөд хятадын хүн
 - С. Умард хятадын хүн
 - Д. Өнгөт нүдтэн
24. Цэгийн оронд тохирохыг нөхнө үү.
Хубилай хаан 1260 онд Төвөдийн ламыг залж, бурхны шашныг төрийн шашин болгов.
- А. Пагва
 - В. Намхайжамц
 - С. Жавзандамба
 - Д. Занабазар
25. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.
-
- НТӨ НТ 1577 он 1586 он
- А. “Түмү”-гийн хэрэг. Эрдэнэ зуу хийдийг байгуулав.
 - В. Содномжамцад “Далай лам” цол соёрхов. Эрдэнэ зуу хийдийг байгуулав.
 - С. Монголын улс төр төв эх нутагтаа шилжив, Дөчин, Дөрвөн хоёр “Их цааз”-ыг батлав.
 - Д. Батмөнх Даян хаан Монголыг захирав. Занабазарыг Анхдугаар Богдоор өргөмжлөв.
26. 1206 онд Чингис хаан шадар хишигтэн цэргийн тоог 10 мянга болгожээ. Уг үйл явдал одоогоос хэдэн жилийн өмнө буюу Чингисийн тооллын хэдэн онд бэ?
- А. 3229 жилийн өмнө буюу Чингисийн тооллын 45 онд
 - В. 817 жилийн өмнө буюу Чингисийн тооллын 45 онд
 - С. 3229 жилийн өмнө буюу Чингисийн тооллын 1 онд
 - Д. 817 жилийн өмнө буюу Чингисийн тооллын 1 онд

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

- а. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.**
б. Зөв хариулт бүр нэг оноотой.

2.1. Монголын өвөг түүхийн үед холбогдох нээлт болон дурсгалуудыг хамрах үетэй нь зөв харгалзуулна уу.

- | | |
|----------------|---------------------------------|
| а. Гал | 1. Неолит |
| б. Нум сум | 2. Дээд палеолит |
| с. Хэл яриа | 3. Дунд палеолит |
| д. Шавар ваар | 4. Хүрлийн үе, түрүү төмрийн үе |
| е. Буган хөшөө | 5. Мезолит |

2.2. Чингис хаантай холбогдох үйл явдлуудыг он цагтай нь зөв харгалзуулна уу.

- | | |
|---|------------|
| а. Тэмүжин Мэргидийн довтолгоонд өртөж, Бөртийг алдав. | 1. 1179 он |
| б. Хар зүрхний Хөх нуурт Монгол улсын хаанд өргөмжлөв. | 2. 1190 он |
| с. Далан балжудад болсон байлдаанд Чингис хаан ялагдав. | 3. 1203 он |
| д. Улз голд Татар аймгийг бут цохив. | 4. 1189 он |
| е. Чингис хаан Хэрэйд улсыг мөхөөв | 5. 1196 он |

2.3. Эртний улсуудыг түүхэн үйл явцтай нь зөв харгалзуулна уу.

- | | |
|-----------|--|
| а. Хятан | 1. 552 онд Захиргаанд нь байсан Түрэгүүд бослого гаргав. |
| б. Сяньби | 2. 235 онд задрав. |
| с. Нирун | 3. Өндөр тэрэгтний улс хэмээн нэрлэгдсэн. |
| д. Уйгур | 4. 12 жилийн он тооллыг анх хэрэглэж байсан. |
| е. Хүннү | 5. Елюй овгийн Амбагян хаан болов. |